



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 1/57

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “ж”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацаа сунгагдсантай холбогдуулан аймаг, сумдын төвөөс гарах, орох иргэд, автомашины хөдөлгөөнийг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08.00 цагаас 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 06.00 цаг хүртэлх хугацаанд зогсоосугай.

Хоёр. 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүр, зоогийн газруудад 09:00-15:00 цагийн хооронд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг зөвшөөрсүгэй.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын газрын дарга, (Ш.Төрбат), Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн хурандаа О.Амарсанаа), Автотээврийн төвийн дарга, (Ц.Бямбацогт) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



482010182